



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Тамирчдын өдрийг тэмдэглэн
өнгөрүүлэх тухай


Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохин байгуулах журам”-ын 4.1.19 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тамирчдын өдрийг 2015 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн Ням гарагт орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Улаанбаатар хотноо Тамирчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардлыг үндэсний шигшээ багийн зардлаас шийдвэрлэхийг Биеийн тамир спортын хөгжлийн төв /П. Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Тамирчдын өдрийг орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Бакытжан/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 08 өдрийн
№26 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛЫН ТАМИРЧДЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: П. Бат-Эрдэнэ Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн дарга

Гишүүдэд : Б.Баярхүү, Эрүүл мэнд, спортын яамны /ЭМСЯ/
Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын /НБСБХЗГ/ мэрэгжилтэн

Ч.Туул, ЭМСЯамны НБСБХЗГ-ын мэрэгжилтэн

Ц.Баярсайхан, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Захиргаа,санхүүгийн хэлтсийн дарга

Ж.Тунгалаг, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн Нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга

Ц.Одонбаяр, Биеийн тамир,спортын хөгжлийн төвийн Үндэсний шигшээ багийн албаны дарга

А.Болдмаа, Нийслэлийн Биеийн тамир, спортын, газрын Ахлах мэрэгжилтэн